



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 54.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 136 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт тус тус доор дурдсан агуулгатай дараах 1.2.8, 3.1.5 дахь заалтуудыг нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 8 дахь заалт:

“1.2.8 “санхүүгийн туслалцаа” гэж Сангаас Хорооны зөвшөөрлөөр санхүүгийн хүндрэлтэй ХЗХ-нд үйл ажиллагааг нь тогтворжуулах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй үзүүлж буй туслалцааг”;

2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“3.1.5 богино хугацаанд эх үүсвэр нэмэгдүүлэх хүсэлтэй ХЗХ-дод эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэг үзүүлэх”.

2. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1.2.4, 1.2.7 дахь заалтуудыг дараах байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 4 дэх заалт:

“1.2.4 “тогтворжилтын үйлчилгээ” гэж Сангаас гишүүн ХЗХ-нд үзүүлж буй удирдлага, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, ХЗХ-ны эрсдэлийн түвшин, тогтвортой байдалд мониторинг хийх үйлчилгээ, санхүүгийн хүндрэлтэй болон богино хугацаанд эх үүсвэр нэмэгдүүлэх хүсэлтэй ХЗХ-дод эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг”;

2/ 1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 7 дахь заалт:

“1.2.7. “энэ журамд заасан санхүүгийн хүндрэлтэй хадгаламж, зээлийн хоршоо” гэж Сангаас эрсдэлийн түвшинг үнэлэн төлбөрийн чадваргүй болсон гэж үзсэн ХЗХ-г”;

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.1 дэх заалтын “... дагуу...” гэсний дараа “...эргэн төлөгдөх нөхцөлтэй...” гэж нэмсүгэй.

000470

4. Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн "...30..." гэснийг "...ажлын 10..." гэж өөрчилсүгэй.

5. Журамд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН